

ХАНГАЙН БҮСИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ЧУУЛГАН 2017

БОДЛОГЫН УЯЛДАА – БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ БҮС



2017 оны 10 дугаар сарын 12
Хөвсгөл аймаг



АГУУЛГА

Товчилсон нэрсийн жагсаалт	2
Чуулганы тухай.....	3
ХӨТӨЛБӨР	4
Өрсөлдөх чадварын чуулган	5
I. ХАНГАЙН БҮСИЙН ТУХАЙ	6
Хангайн бүсийн өрсөлдөх чадварын тухай	6
Хөвсгөл аймгийн өрсөлдөх чадвар	7
Орхон аймгийн өрсөлдөх чадвар.....	8
Өвөрхангай аймгийн өрсөлдөх чадвар.....	9
Булган аймгийн өрсөлдөх чадвар.....	10
Архангай аймгийн өрсөлдөх чадвар	11
Баянхонгор аймгийн өрсөлдөх чадвар.....	12
II. ЧУУЛГАН.....	13
НЭЭЛТИЙН ҮГ.....	14
ИЛТГЭЛҮҮДИЙН ТОЙМ	15
ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮДИЙН ТОЙМ.....	16
Хэлэлцүүлэг 1: “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо – Бүсчилсэн хөгжил”	16
Хэлэлцүүлэг 2: “Эдийн засгийн төрөлжилт: Хангайн бүсийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь”	18
Хэлэлцүүлэг 3: “Эдийн засгийн төрөлжилт: Хангайн бүсийн ЖДҮ-г хөгжүүлэх нь”	21
Хэлэлцүүлэг 4: “Хангайн бүсийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөв байдал”	24
Хэлэлцүүлэг 5: “Хангайн бүсийн хамтын ажиллагаа: Хурлын дүгнэлт цаашдын алхмууд”	27
ЗУРГИЙН ЦОМОГ	31



ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ

БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАЖХ	Монголын аялал жуулчлалын холбоо
МСҮТ	Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв
МУ	Монгол Улс
МҮХАУТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БОЛОН ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД





ЧУУЛГАНЫ ТУХАЙ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн зүгээс санаачлан, ХБНГУ-ын “Конрад-Аденауэр-Сан”, Хөвсгөл аймгийн ЗДТГ болон МҮХАҮТ-тай хамтран “Хангайн бүсийн өрсөлдөх чадварын чуулган 2017” арга хэмжээг “Бодлогын уялдаа – Байгальд ээлтэй бүс” уриан дор Хөвсгөл аймгийн Мөрөн хотод 2017 оны 10-р сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгууллаа. Чуулга уулзалтад Хангайн бүсийн Хөвсгөл, Булган, Орхон, Өвөрхангай, Архангай болон Баянхонгор аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нар болон холбогдох албаны хүмүүс оролцсоноос гадна Уланбаатар хотоос Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Үндэсний хөгжлийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Зээлийн батлан даалтын сан, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Азийн сан, Монголын аялал жуулчлалын холбоо, болон бизнесийн байгууллагуудын төлөөллүүд оролцов.

Чуулганы хүрээнд “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо-Бүсчилсэн хөгжил”, “Хангайн бүсийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь”, “Хангайн бүсийн ЖДҮ-ийг хөгжүүлэх нь”, “Хангайн бүсийн хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх нь” зэрэг үндсэн дөрвөн хэлэлцүүлэг өрнүүлсэн бол чуулганы хоёр дахь өдөр “Хангайн бүсийн хамтын ажиллагаа, цаашдын алхам” хэлэлцүүлгээр оролцогч аймгууд салбарын бодлогыг бүсийн хэмжээнд хэрхэн уялдуулж, хамтран ажиллах талаар санал бодлоо солилцсоноор чуулган өндөрлөв.

Мөн чуулганы үеэр Хангайн бүсийн бизнес эрхлэгчид Мөрөн хот дахь Чингүнжавын талбайд “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд оролцов.





ХӨТӨЛБӨР

2017 оны 10 дугаар сарын 12

08:30 – 09:00	Оролцогчдын бүртгэл / Хөвсгөл аймгийн танилцуулга
09:00 – 09:30	Нээлтийн үйл ажиллагаа
09:30 – 09:40	Нээлтийн үг: Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатар
09:30 – 09:40	Нээлтийн үг: “Конрад-Аденауэр-Сан”-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Др. Даниел Шмюкинг
09:40 – 10:10	Илтгэл 1: “Хангайн бүсийн өрсөлдөх чадварын өнөөгийн төлөв байдал” ЭЗБӨЧСТ-ийн Удирдах зөвлөлийн дарга П.Цагаан
10:10 – 10:40	Илтгэл 2: “Компанийн нийгмийн хариуцлага ба тогтвортой хөгжлийн зорилтууд” “Конрад-Аденауэр-Сан”-ийн төслийн менежер Б.Сүхбат
10:40 – 11:00	Цайны завсарлага
11:00 – 12:30	Хэлэлцүүлэг 1: “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо-Бүсчилсэн хөгжил” Илтгэл: Үндэсний хөгжлийн газар, судалгаа шинжилгээний албаны дарга А.Мөнхболд
12:30 – 12:40	Оролцогчдын дурсгалын зураг
12:40 – 13:50	Үдийн зоог
13:50 – 15:20	Хэлэлцүүлэг 2: “Эдийн засгийн төрөлжилт: аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь” Илтгэл: БОАЖЯ-ны аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Ц.Гэрэлсайхан
15:20 – 15:40	Цайны завсарлага
15:40 – 17:10	Хэлэлцүүлэг 3: “Эдийн засгийн төрөлжилт: ЖДҮ-г хөгжүүлэх нь” Илтгэл: Зээлийн батлан даалтын сангийн, Захиргаа төлөвлөлтийн газрын дарга Б.Ариунаа
17:10 – 17:40	Өдрийн тойм: МҮХАҮТ-ын орлогч дарга М.Сарандаваа
18:00 – 19:30	Хүлээн авалт

2017 оны 10 дугаар сарын 13

08:30 – 09:00	Оролцогчдын бүртгэл
09:00 – 09:10	Мэндчилгээ: Азийн Сангийн Монгол дахь салбарын суурин төлөөлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Эдвард Андерсон
09:10 – 10:40	Нэгдсэн хэлэлцүүлэг 4: “Хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөв” Илтгэл: ХХААХҮЯ-ны бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Х.Алтангэрэл
10:40 – 12:00	Нэгдсэн хэлэлцүүлэг 5: “Хангайн бүсийн хамтын ажиллагаа: Хурлын дүгнэлт цаашдын алхмууд”
12:00 – 12:10	Хаалтын үг: Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатар ЭЗБӨЧСТ-ийн Удирдах зөвлөлийн дарга П.Цагаан
12:10 – 13:10	Үдийн хоол / Үзэсгэлэн худалдаа
13:10 – 17:00	Хатгал тосгоны аялал жуулчлалын салбартай танилцах
18:30 – 20:00	Оройн зоог



АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ЧУУЛГАН



- Аймгуудын өрсөлдөх чадварын анхдугаар чуулган
- 2014 оны 10-р сарын 8,9
- ЭЗБӨЧСТ-с санаачлан Конрад-Аденауэр-Сангийн дэмжлэгтэй
- Хорин нэгэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга мөн МҮХАҮТ-ын орон нутаг дахь салбар танхимуудын дарга нар зэрэг 60 гаруй төлөөлөгчид оролцсон.



- Зүүн бүсийн өрсөлдөх чадварын чуулган 2015 – “Хөгжлийн төлөөх түншлэл”
- 2015 оны 10-р сарын 8,9
- ЭЗБӨЧСТ-с санаачлан Конрад-Аденауэр-Сангийн дэмжлэгтэй
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт хот
- Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймгууд болон Улаанбаатар хотоос нийт 140 гаруй төлөөлөгчид оролцсон.



- “Говийн бүсийн өрсөлдөх чадварын чуулган 2016 – Нэг говь нэг зорилго”
- 2016 оны 11-р сарын 3,4
- ЭЗБӨЧСТ - с санаачлан Конрад-Аденауэр-Сангийн дэмжлэгтэй
- Дундговь аймгийн Мандалговь хот
- Улаанбаатар хотоос болон Дундговь, Өмнөговь, Дорноговь аймгийн 200 гаруй төлөөлөгчид оролцсон.

Дэлгэрэнгүй мэдээллийг aimagindex.mn-с авна үү.




I. ХАНГАЙН БҮСИЙН ТУХАЙ

Хангайн бүсийн өрсөлдөх чадварын тухай


Хангайн бүсийн зургаан аймаг болох Хөвсгөл, Орхон, Булган, Өвөрхангай, Архангай болон Баянхонгор нь 21 аймгийн нийт ДНБ-ний 37%-ийг бүрдүүлж байна. Хамгийн олон аймаг ордог бүс бөгөөд өрсөлдөх чадварын дундаж үнэлгээгээр таван бүсээс 64,3 оноотойгоор дөрөвт орсон. 2016 онд өрсөлдөх чадварын үнэлгээгээрээ Орхон, Хөвсгөл болон Баянхонгор аймгуудын байр өөрчлөгдөөгүй бол Архангай, Булган аймгуудын эрэмбэ нь ухарчээ. Харин Өвөрхангай аймаг 18-д эрэмбэлэгдэж байсан бол 14-руу урагшилсан байна.

Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ 2016



Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл аймгуудын ДНБ 4 жил дараалж өссөн, Булган аймгийн ДНБ өнгөрсөн жил буурсан бол Орхон аймгийн хувьд сүүлийн 3 жил ДНБ нь буурлаа.

ДНБ, тэрбум төгрөгөөр




Хангайн бүсийн өрсөлдөх чадварын давуу тал: Малын тоогоор Архангай 1-т, Өвөрхангай 2-т, Хөвсгөл 3-т, Булган 5-т, Баянхонгор 8-т эрэмбэлэгддэг мөн ДНБ-ний хэмжээгээр Орхон 1-т, Хөвсгөл 5-д, Өвөрхангай 6-д, Архангай 7-д, Баянхонгор 9-т эрэмбэлэгддэг.

Хангайн бүсийн өрсөлдөх чадварын сул тал: Дундаж цалингаар Хөвсгөл 21-т, Өвөрхангай 19-д, Архангай 18-д, Баянхонгор 13, Булган 11-т эрэмбэлэгддэг бол хүний хөгжлийн индексээр Хөвсгөл 21-т, Өвөрхангай 20-д, Баянхонгор 18-д, архангай 15-д, Булган 14-т эрэмбэлэгддэг.




ХӨВСГӨЛ АЙМГИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР



ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2015	Эрэмбэ
Нутаг дэвсгэрийн хэмжээ (мянган км ²)	101	6
Сумдын тоо	23	
Хүн амын тоо (мянга)	127	1
ДНБ (оны үнээр, тэрбум төгрөг)	515	5
Нэг хүнд ногдох ДНБ (оны үнээр, мянган төгрөг)	4049	17
Ажилгүйдлийн түвшин (%)	6.7	9
Инфляци (%)	2.3	9

Өрсөлдөх чадварын төлөв байдал, эрэмбээр




Тулгарч буй бэрхшээлүүд ба шийдэл

- Дэд бүтцийн асуудлуудыг сайжруулах (цэцэрлэг барих, битүү зах барих, машины зогсоол, ногоон байгууламж, халуун ус, гэрэлтүүлэг гэх мэт)
- Залуу боловсон хүчнийг сургалтанд хамруулж ажлын байраар хангах
- Төрийн албан хаагчдын хүнд суртлыг арилгаж түргэн шуурхай болгох
- Бизнес эрхлэгчдийг татвар, зээл болон газар олгох замаар дэмжих
- Аялал жуулчлалыг бодлогоор дэмжиж ажлын байр бий болгох



ОРХОН АЙМГИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР


Эдийн засгийн тамир тэнхээ



ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2015	Эрэмбэ
Нутаг дэвсгэрийн хэмжээ (мянган км ²)	1 2	1
Сумдын тоо	2	
Хүн амын тоо(мянга)	97.5	6
ДНБ (оны үнээр,тэрбум төгрөг)	1,060	1
Нэг хүнд ногдох ДНБ (оны үнээр,мянган төгрөг)	10860	1
Ажилгүйдлийн түвшин (%)	2.2	1
Инфляци (%)	0.6	9

Өрсөлдөх чадварын төлөв байдал, эрэмбээр




Тулгарч буй бэрхшээлүүд ба шийдэл

- Бизнесийн үйл ажиллагааг дэмжиж, бизнес эрхлэх зөвшөөрөл авах үйл ажиллагааг сайжруулах
- Татварын таатай, уян хатан орчин бүрдүүлэх
- Орон нутгийн томоохон үйлдвэрүүд орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлэх
- Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах
- Чадварлаг ажиллах хүчний олдоцыг нэмэгдүүлэх




ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР



ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2015	Эрэмбэ
Нутаг дэвсгэрийн хэмжээ (мянган км ²)	63	14
Сумдын тоо	19	
Хүн амын тоо (мянга)	113	2
ДНБ (оны үнээр, тэрбум төгрөг)	414	6
Нэг хүнд ногдох ДНБ (оны үнээр, мянган төгрөг)	3 670	20
Ажилгүйдлийн түвшин (%)	3,6	2
Инфляци (%)	7	20

Өрсөлдөх чадварын төлөв байдал, эрэмбээр




Тулгарч буй бэрхшээлүүд ба шийдэл

- Дулааны цахилгаан станц барих
- Бизнес эрхлэгчдэд бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж өгөх
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Банкны зээлийн хүүг бууруулж, хугацааг уртасгах
- Татварын дарамтыг бууруулж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах



БУЛГАН АЙМГИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР


Эдийн засгийн тамир тэнхээ



ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2015	Эрэмбэ
Нутаг дэвсгэрийн хэмжээ (мянган км ²)	49	16
Сумдын тоо	16	
Хүн амын тоо(мянга)	60	17
ДНБ (оны үнээр, тэрбум төгрөг)	306	16
Нэг хүнд ногдох ДНБ (оны үнээр, мянган төгрөг)	5,086	8
Ажилгүйдлийн түвшин (%)	4.6	4
Инфляци (%)	1.7	8

Өрсөлдөх чадварын төлөв байдал, эрэмбээр




Тулгарч буй бэрхшээлүүд ба шийдэл

- Ажлын байрны хүрэлцээг сайжруулах
- Татварын бодлогыг шинэчилж үе шаттайгаар бууруулах
- Банкны зээлийн хүүг бууруулах
- ЖДҮ-г дэмжиж, үйлдвэрлэл хөгжүүлэх
- Түүхий эдийн үнийг нэмэгдүүлж, томоохон худалдааны төв байгуулах




АРХАНГАЙ АЙМГИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР



ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2015	Эрэмбэ
Нутаг дэвсгэрийн хэмжээ (мянган км ²)	55	15
Сумдын тоо	19	
Хүн амын тоо(мянга)	93	7
ДНБ (оны үнээр, тэрбум төгрөг)	410	7
Нэг хүнд ногдох ДНБ (оны үнээр, мянган төгрөг)	4430	12
Ажилгүйдлийн түвшин (%)	5.0	6
Инфляци (%)	11.9	21

Өрсөлдөх чадварын төлөв байдал, эрэмбээр




Тулгарч буй бэрхшээлүүд ба шийдэл

- Төр хувийн хэвшлийн уялдааг сайжруулж, татварын дарамтыг багасгах
- ЖДҮ-ийг татвар, зээлийн бодлого болон гадаадын төсөл хөтөлбөрт хамруулж дэмжих
- Дэд бүтцийн асуудал буюу томоохон үйлдвэр, худалдааны төв байгуулах, хотын үзэмж хогийн сав гэх мэт
- Банкны зээлийн хүүг бууруулж зээл олгох хугацааг сунгах
- Орон нутгийн ажлын байр нэмэгдүүлэх




БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР



ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2015	Эрэмбэ
Нутаг дэвсгэрийн хэмжээ (мянган км ²)	116	4
Сумдын тоо	20	
Хүн амын тоо(мянга)	83.5	9
ДНБ (оны үнээр, тэрбум төгрөг)	369	9
Нэг хүнд ногдох ДНБ (оны үнээр, мянган төгрөг)	4,422	13
Ажилгүйдлийн түвшин (%)	6.4	8
Инфляци (%)	6.4	19

Өрсөлдөх чадварын төлөв байдал, эрэмбээр



Тулгарч буй бэрхшээлүүд ба шийдэл

- Орон нутгийн ААН, бизнесийн байгууллагууд, ЖДҮ эрхлэгчдыг зээлийн хүүг бууруулах зэрэг бодлогоор дэмжих
- Мэдлэг чадвартай залуу боловсон хүчнийг олноор бэлтгэх
- Төрийн татварын дарамтыг багасгах. Мөн бизнес эрхлэгчдэд цаг алдалгүй мэдээлэл өгдөг байх
- Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт өргөнөөр хамруулдаг байх. Экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг сайн дэмжих.
- Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуултын сувгийг нэмэгдүүлэх



II. ЧУУЛГАН

Хөвсгөл аймгийн зүгээс чуулганд оролцогч нарт зориулж өөрсдийн уламжлал, соёл урлаг, дуу хуураар мэндчилгээ дэвшүүлэн чуулганы үйл ажиллагааг эхлүүлэв.





НЭЭЛТИЙН ҮГ

Л.Төмөрбаатар

Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга



Хэлсэн үгнээс:

ЭЗБӨЧСТ нь “Хангайн бүсийн өрсөлдөх чадварын чуулган 2017”-г Хөвсгөл аймгийн Мөрөн хотод зохион байгуулах хүсэлт тавьсныг бид талархан хүлээн авч улмаар чуулган өнөөдөр зохион байгуулагдаж байна. Хангайн бүсийн аймгууд нэг дор цуглан өөрсдийн өрсөлдөх чадварын давуу талаа ашиглан хөгжлийн тулгуур салбаруудаа цаашид хамтран хөгжүүлэх талаар хэлэлцэх гэж байна. Хөвсгөл аймгийн хувьд өрсөлдөх чадвар нь жил бүр сайжирч байгааг өрсөлдөх чадварын тайлангаас харж болохоор байна. Энэ нь аймгийн урт болон дунд хугацааны бодлогын үр дүн хэмээн үзэж, цаашдаа улам илүү хичээн ажиллах болно. Ингээд Хангайн бүсийн чуулганы үйл ажиллагаа нээснийг мэдэгдэж, чуулганд амжилт хүсье.”

Др. Даниел Шмюкинг

“Конрад-Аденауэр-Сан”-ийн Монгол дахь
суурин төлөөлөгч

(Видео мэндчилгээ)



Хэлсэн үгнээс:

“Юуны өмнө манай сангийн талаар сайн мэддэггүй хүмүүст хэлэхэд Конрад Аденауэр сан нь 1993 оноос Монгол Улсад үйл ажиллагаагаа тогтвортой явуулж буй ХБНГУ-ын улс төрийн сан юм. Бид Монгол Улсын ардчиллын үйл явцыг анхнаас нь дэмжиж ирсэн бөгөөд үүнийг олон төрлийн төслүүдээрээ дамжуулан хэрэгжүүлж байна. Манай сангийн Монголд анхаарлаа хандуулдаг нэг гол сэдэв бол нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг юм. Тэр дундаа компанийн нийгмийн хариуцлагыг хөхүүлэн дэмждэг. Монголын хөгжилд энэ сэдэв багагүй ач холбогдолтой гэж бид үздэг. Нийгмийн хариуцлагатай компаниуд улсынхаа эдийн засагт тус нэмэр болохоос гадна тэдний хувьд ч олон улсын хөрөнгө оруулагчдыг өөртөө татах нэг боломж гэж үздэг. Аж ахуй нэгжүүдийн ирээдүйгээ бодсон, ухаалаг үйл ажиллагаа, бодлого гадаад хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах нэг шалтгаан болдог. Эцэст нь хэлэхэд та бүхэн чуулганы үеэр сонирхолтой яриа хэлэлцээр өрнүүлж та бүхний ирээдүйн ажил, амьдралд тус дэм болно гэдэгт итгэж байна. Чуулганд амжилт хүсье.”



ИЛТГЭЛҮҮДИЙН ТОЙМ

ИЛТГЭЛ

“Хангайн бүсийн өрсөлдөх чадварын өнөөгийн төлөв байдал”

П.Цагаан – ЭЗБӨЧСТ-ийн Удирдах зөвлөлийн дарга



Илтгэлээс онцлох:

- Аймгуудын өрсөлдөх чадварын тайланг 6 дахь жилдээ гаргахаар ажиллаж байна.
- Уг тайлан нь 4 хүчин зүйлийн 181 шалгуур үзүүлэлт ашигладаг. 21 аймгийн 1050 аж ахуй нэгжээс санал асуулга авдаг.
- Хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй.
- Хангайн бүс өрсөлдөх чадварын дундаж оноогоор 5 бүсээс дөрөвт эрэмбэлэгдэж байна.
- Хангайн бүсийн аймгуудад дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай байна.
- Улс орны нутаг дэвсгэрийн хаана амьдарч буйгаас үл хамааран иргэн бүр сонголт хийх адил тэгш боломжоор хангагдаж хэмээнэ Монгол Улсын өрсөлдөх чадвар сайжирна.

ИЛТГЭЛ

“Компанийн нийгмийн хариуцлага ба тогтвортой хөгжлийн зорилтууд”

Б.Сүхбат – “Конрад-Аденауэр-Сан”-ийн төслийн менежер



Илтгэлээс онцлох:

- Компаний нийгмийн хариуцлага гэдэг нь компани өөрийн үйл ажиллагаагаа эдийн засаг, байгаль орчин, нийгэм олон нийтийн орчинд тогтвортой байдлаар нөлөөлөх тэр хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хэлнэ.
- Компаниуд өөрсдийн оролцоог улам нэмэгдүүлэхэд тодорхой улс төрийн тогтолцоо, тогтвортой эрх зүйн орчин болон урамшуулал эсвэл татварыг бууруулах зэргээр дэмжих хэрэгтэй гэж үздэг.
- Хариуцлагатай бизнесүүд нь “байх ёстой норм” болж байна.
- Компаниудын нийгмийн хариуцлага муу байгаа нь Монголын бизнесийн соёл, хууль эрх зүй, улс төрийн тогтолцоо дутмаг байгаагаас болж байна.
- Хэрэглэгчид компаниудаас нийгэм ба байгаль орчны хувьд хариуцлагатай байхыг хүсэж байна.



ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮДИЙН ТОЙМ

Хэлэлцүүлэг 1: “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо – Бүсчилсэн хөгжил”

Чиглүүлэгч: ЭЗБӨЧСТ-ийн Ерөнхий захирал Б.Лакшми



Тэргүүлэх оролцогчид:

1. Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатар
2. Булган аймгийн ИТХ-ын дарга М.Оюунбат
3. Орхон аймгийн ИТХ-ын дарга П.Пүрэвхагва
4. Өвөрхангай аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж
5. Үндэсний хөгжлийн газар, судалгаа шинжилгээний албаны дарга А.Мөнхболд

ИЛТГЭЛ

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо – Бүсчилсэн хөгжил

Үндэсний хөгжлийн газар, судалгаа шинжилгээний албаны дарга А.Мөнхболд



Илтгэлээс онцлох:

- Үндэсний хөгжлийн газар нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, уялдаа, нэгдсэн бодлогыг боловсруулах, хэрэгжилтийг хангах төрийн захиргааны байгууллага юм.
- “Бүсчилсэн хөгжлийн бодлого” боловсруулах, бэлтгэх ажлыг хангах ажлын хэсэг байгуулагдсан.
- Бүсчилсэн хөгжлийн орон нутгийн хэлэлцүүлгийг Хангайн бүсийн Хөвсгөл, Орхон, Булган, Баянхонгор аймагт зохион байгуулаад байна.
- Үндэсний хөгжлийн газрын дарга болон 21 аймгийн засаг дарга нар 2017 онд хөгжлийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр хамтран ажиллах гэрээг 2017 оны 01-р сарын 06 ны өдөр байгуулсан.
- Хангайн бүсэд аялал жуулчлалын хөрөнгө оруулалтыг ихээр нэмэгдүүлэх шаардлагатай.



Хэлэлцүүлгийн асуулт, хариултаас товч:

Асуулт: Хөвсгөл аймгийн хөгжлийн тулгуур салбар юу вэ? Мөн тулгамдаж буй асуудлууд?

Л.Төмөрбаатар: Манай аймгийн хувьд эдийн засгийн тамир тэнхээ харьцангуй сул тул цаашдаа эдийн засгаа солонгоруулахад түлхүү анхаарч ажиллана. Хамгийн сайн чанарын гантиг Хөвсгөлд байдаг, үүнийг эргэлтэнд оруулна. Мөн удахгүй 2,5 сая долларын өртөгтэй махны үйлдвэр ашиглалтанд орно. Энэхүү үйлдвэрийг түшиглэн дайвар бүтээгдэхүүний боловсруулалтыг хөгжүүлнэ. Хөвсгөл аймаг нь аялал жуулчлалын тулгуур төв гэгддэг ба энэ онд одоогийн байдлаар 90,263 жуулчин ирсэн. 112 тусгай зөвшөөрөлтэй ААН Хөвсгөл далай, Дархадын хотгорт үйл ажиллагаа явуулдаг. Нийтдээ 7,114,000₮ татвар төлдөг нь үнэхээр чамлалттай байна. Тэгтэл тэр орчмын хогийг 10 сая гаруй төгрөгөөр цэвэрлэж байна.

Асуулт: Булган аймгийн хөгжлийн тулгуур салбар юу вэ? Мөн тулгамдаж буй асуудлууд?

М.Оюунбат: Булган аймгийн хувьд улсаас татаас авдаггүй харин улсдаа мөнгө өгдөг зургаан аймгийн нэг. Дотоодын нийт бүтээгдэхүүний 70 орчим хувийг ХАА, газар тариалангийн салбар эзэлдэг. Гэвч сүүлийн 30, 40 жил Булган аймагт томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжсэнгүй. Мөн сүүлийн 20 жилд Булган аймагт нэг ч алтны лиценз өгөөгүй. Эгийн голын цахилгаан станц болон Тавантолгой, Оюу-толгойг усаар хангах Орхон-Говь төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эрдэнэт үйлдвэрээс ус ашигласны төлбөр 12 тэрбум төгрөгийг авдаг. Мөн Хангайн бүсийн босоо тэнхлэгийн замыг тавих нь бүсийн хөгжлийг хурдасгах болно.

Асуулт: Цаашид хөгжлийн бодлого, төлөвлөлтөө хэрхэн уялдуулж хамтран ажиллана гэж харж байгаа вэ?

П.Пүрэвхагва: Босоо тэнхлэгийн дэд бүтцийн асуудлыг шийдэхгүйгээр бүсийн хамтын ажиллагаа сайжрах хэцүү. Эрдэнэт хотод асар их төвлөрөл үүсээд байна. Хүн амын тоо албан ёсоор 110,000 гэдэг ч үнэндээ 130,000 хүн амьдардаг. Бид Шинжлэх ухаан технологийн парк байгуулсан. Үүний дагуу эрүүл мэнд шинжлэх ухааны чиглэл болон модон хийцийг хөгжүүлж болно. Орхон аймаг гэхээр зөвхөн Эрдэнэт үйлдвэрээр төсөөлдөг. Гэхдээ манайд Эрдэнэт хивс зэрэг өөр том үйлдвэрүүд байгаа. Зах зээл, хэрэглээ нь байгаа учир "Агропарк" байгуулах гэж буй.

Асуулт: Өвөрхангай аймгийн хувьд Хангайн бүсийн аймгуудтай хамтын ажиллагаа ямар түвшинд байдаг вэ? Хамтын ажиллагааны ямар хэлбэр байвал зохистой вэ?

А.Ишдорж: Өвөрхангай аймаг нь 7 сая гаруй малтайгаар улсдаа тэргүүлдэг. Бидэнд малыг яаж эдийн засагт эргэлдүүлэх вэ? бэлчээрийн даацын асуудлыг яаж шийдэх вэ? гэдэг асуудлууд тулгараад байна. Үүний хүрээнд махны үйлдвэр байгуулж байгаа. Булган, Архангай аймгуудтай хамтраад аялал, жуулчлалын мэдээллийн төвийг байгуулах талаар ажиллаж байна. Босоо чиглэлийн автозамыг барих шаардлагатай. Мөн аливаа бодлого тогтвортой байх хэрэгтэй. Нам, засаг солигдохоор өмнөх орон нутгийн бодлогыг үгүйсгэж эхэлдэг. Манай аймаг хамгийн бага лицензтэй аймаг. Төсвийнхөө 80%-ийг татаасаар авдаг.

Оролцогчдын асуулт (С.Баярмагнай, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын гадаад



харилцаа, аялал жуулчлалын албаны дарга): Бүсчилсэн хөгжлийн бодлого өөрчлөгдөх гэж байгаа юм уу эсвэл тодотгол хийх гэж байгаа юм уу?

А.Мөнхболд: Бид 2001 онд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсан. Гэхдээ энэ нь бодлогогүй буюу алсын хараагүй байсан. Өнгөрсөн 16 жилийн хугацаанд туулсан алдаа оноо, туршлага дээрээ суурилан бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулахаар болсон. Бүсчилсэн хөгжлийн бодлогын зорилго нь “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-г хангах юм. Өөрөөр

хэлбэл Монгол Улсын ихэнх бодлогыг аваад үзэхээр агаар дээр байдаг, хөрсөн дээр буусан нь байдаггүй. Жишээ нь төвийн бүсэд гэхэд 5 том цементийн үйлдвэр байна. Эдгээр үйлдвэрүүдийн нийт хүчин чадал нь Монгол Улсын эрэлтийг давж байна. Гэтэл баруун бүс, зүүн бүсд цементийн үйлдвэр алга. Энэ бол бодлого биш ээ. Бид бүсчилсэн хөгжлийн бодлогоор байршлын, орон зайн төлөвлөлтийг маш сайн болгоно. Судалгааны үндсэн дээр бид аж үйлдвэрийн 5 бүс, 27 дэд бүсийг гаргаж ирсэн.

Хэлэлцүүлэг 2: “Эдийн засгийн төрөлжилт: Хангайн бүсийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь”

Чиглүүлэгч: МҮХАҮТ-ын орлогч дарга М.Сарандаваа



Тэргүүлэх оролцогчид:

1. БОАЖЯ-ны аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Ц.Гэрэлсайхан
2. Үндэсний хөгжлийн газрын зөвлөх С.Намжилмаа
3. Монголын аялал жуулчлалын холбооны гадаад харилцаа, маркетингийн менежер Б.Булган
4. Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны дарга С.Баярмагнай
5. Хөвсгөл аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн Д.Дуламсүрэн
6. Хатгал тосгоны захирагч, Б.Ганбаатар



ИЛТГЭЛ

“Эдийн засгийн төрөлжилт: Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь”

БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Ц.Гэрэлсайхан



Илтгэлээс онцлох:

- Аялал жуулчлалын салбар ДНБ-ний 5,3 хувийг эзэлдэг бөгөөд 54,000 ажлын байр, 312 сая ам.долларын орлого олдог бөгөөд сүүлийн жилд 404,000 жуулчин ирсэн.
- Хятад, ОХУ, БНСУ-ын жуулчид хамгийн их ирдэг.
- БОАЖЯ Аялал жуулчлалын бүсчилсэн хөгжлийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Хангайн бүс нь Монгол Улсын аялал жуулчлалын гол бүс юм.
- Хангайн бүсэд нийт 151 жуулчны бааз, 140 зочид буудал болон дэн буудал үйл ажиллагаа явуулж байна.
- Өвөрхангай аймгийн Орхон голын хөндийд Аялал жуулчлалын парк байгуулах, Хөвсгөл нуурын бүсэд нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл зэрэг ажлуудыг “Хөгжлийн зам” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийнэ.

Хэлэлцүүлгийн асуулт, хариултаас товч:

Асуулт: Үндэсний хөгжлийн газар аялал жуулчлалтай холбоотой, ялангуяа Хангайн бүсийн аялал жуулчлалын ямар бодлого баримталж байна вэ?

С.Намжилмаа: ҮХГ бүх салбаруудын хөгжлийн бодлогыг уялдуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэгэхээр аялал жуулчлалын хувьд олон салбаруудыг хооронд нь уялдуулж байдаг бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргадаг. Жишээ нь аялал жуулчлал гэхээр дэд бүтэц, үйлчилгээ аль аль нь ордог учир олон салбаруудыг хамардаг. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд бид хөгжлийн ерөнхий схем гэсэн зураглалыг хийж байгаа. Үүн дотор нэг гол зүйл нь аялал жуулчлалын нэгдсэн зураглал юм. Баруун таван аймгийн аялал жуулчлалын газрууд нийлээд баруун бүсийн аялал жуулчлалын нэгдсэн маршрутыг бий болгох санамж

бичиг гаргасан. Үүнтэй адил бид энэхүү чуулганы хүрээнд аялал жуулчлалын нэгдсэн маршрут гаргая гэсэн зөвлөмж гаргавал их ач холбогдолтой.

Асуулт: Гадаад жуулчид ирээд юу худалдаж авч байна вэ? Тэдэнд тохирсон контентийг бий болгож чадаж байна уу?

Б.Булган: Монголын аялал жуулчлалын холбоо 1992 онд байгуулагдсан. МАЖХ гадаадын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд Монголын компаниудыг оролцуулдаг. Одоогийн байдлаар бид аялал жуулчлалын уламжлалт бүтээгдэхүүнүүдээ борлуулаад цаашдаа шинээр ямар бүтээгдэхүүнүүдийг бий болгох, тэднийгээ хэрхэн сурталчилах зэрэг дээр анхаарах хэрэгтэй.

Асуулт: Аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын компаниудын байгаль орчинд хандаж



буй хандлага, үзүүлж буй сөрөг болон эерэг нөлөөлөл нь юу байдаг вэ? Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах талаар саналаа хэлнэ үү.

С.Баярмагнай: Баянхонгор аймаг Хангайн бүс дотроо аялал жуулчлалаар сул хөгжсөн аймаг юм. Түрүүн хэлсэнчлэн ердөө 4, 5 жуулчны бааз байдаг. Орон нутагт байдаг аялал жуулчлалын компаниуд хаанаас зөвшөөрөл авсан нь мэдэгдэхгүй байгалийн үзэсгэлэнт газарт өөрсдийн объектоо барьчихсан байдаг. Улмаар иргэд болон компаниудын хооронд зөрчил гарах тохиолдлууд байна. Тэгэхээр орон нутагт үйл ажиллагаа явуулах гэж буй компаниуд орон нутгаасаа зөвшөөрөл авдаг болмоор байна. Мөн компаниуд зөвхөн өөрсдийн үйл ажиллагаанд хөрөнгөө оруулахаас биш байгалийн үзэсгэлэнт газартаа хөрөнгө оруулахгүй байна.

Асуулт: Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийг хурдасгахад юу хийж байна вэ?

Д.Дуламсүрэн: Аялал жуулчлалын салбар нь манай аймгийн тэргүүлэх салбаруудын нэг. Бид 50-р өргөрөгөөс хойшхи газар нутгийг аялал жуулчлалын бүс нутаг хэмээн тодорхойлдог. 2015 онд аймгийн ИТХ-н тогтоолоор аялал жуулчлалын салбарын урт хугацааны бодлогын баримт бичгийг гаргасан. Үүнд Монгол Улсын эко аялал жуулчлалын жишиг аймаг болно гэсэн том зорилтыг тавьсан байгаа. Мөн Хөгжсөн Хөвсгөл 2030 хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд анхаарч байна. Бид

байгалийн, түүхэн, соёлын гэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд түлхүү анхаарч байна.

Асуулт: Бидэнд олон бодлого, хөтөлбөр байна. Эдгээр бодлого, хөтөлбөрт Хатгал тосгоны хувьд оролцож, хэрэгжүүлж чадаж байна уу?

Б.Ганбаатар: 100,000 жуулчин авчраад нэг жуулчинаас \$1 авах, эсвэл 1000 жуулчин авчраад нэгнээс нь \$100 авах хоёр өөр хэрэг ээ. Жуулчдаас олсон мөнгөнөөс хэн хүртээд, юу хийж байна вэ? Нутгийн иргэдэд түшиглэсэн жуулчлал нь иргэдийн хувьд онд орох асуудал болохоос супер эдийн засгийг бүтээх асуудал биш юм. Сум бүрт адил хэмжээний мөнгө олгоод байх нь буруу. Хамгийн их мөнгө олж байгаа газар нь илүү их мөнгө оруулж байх нь зөв.

Асуулт: БОАЖЯ аялал жуулчлалаас үүдсэн бохирдолын асуудлыг яаж шийдэж байна?

Ц.Гэрэлсайхан: Аялал жуулчлалын үйл ажиллагаа утаагүй боловч мэдээж зөв менежмент хийхгүй бол байгаль орчинд сөрөг нөлөөтэй. Хог хаягдал гэх мэт маш их бохирдол гарч байгаа. Тэгэхээр үүнийг зөв шийдэх хэрэгтэй. Ялангуяа энэ асуудал нь цэнгэг устай Хөвсгөл нуурын хувьд тулгамдсан асуудал болоод байна. Өнгөрсөн зун БОАЖЯ болон аймгийн удирдлагууд хамтраад аялал жуулчлалын байгууллагуудад хэмжилт, шалгалт хийсэн. Жуулчны баазууд стандартад нийцэж байгаа эсэх, нийцэхгүй байгаа тохиолдолд засварлах аль эсвэл тусгай зөвшөөрлийг нь хураах хүртэл арга хэмжээ авахаар ажиллаж байна



Хэлэлцүүлэг 3: “Эдийн засгийн төрөлжилт: Хангайн бүсийн ЖДҮ-ийг хөгжүүлэх нь”

Чиглүүлэгч: Би Эф Эй Эс ХХК-ын гүйцэтгэх захирал Л.Болормаа



Тэргүүлэх оролцогчид:

1. ЗГХЭГ, Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Э.Бат-Идэр
2. Зээлийн батлан даалтын сангийн, захиргаа төлөвлөлтийн газрын дарга, Б.Ариунаа
3. Үндэсний хөгжлийн газар, судалгаа шинжилгээний албаны дарга А.Мөнхболд
4. Санхүүгийн зохицуулах хорооны судалгаа эрсдэлийн шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Наранжаргал
5. Хөвсгөл аймгийн худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга Ж.Сарангэрэл

ИЛТГЭЛ

Хангайн бүсийн ЖДҮ-ийг хөгжүүлэхэд ЗБДС-ийн оролцоо “Эх үүсвэртэй батлан даалт” бүтээгдэхүүний товч танилцуулга

Зээлийн батлан даалтын сан,
Захиргаа төлөвлөлтийн газрын дарга Б.Ариунаа



Илтгэлээс онцлох:

- 2013 оны 4-р сарын 11-с ЗБДС-ийн үйл ажиллагаа эхэлсэн.
- Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч, барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргадаг.
- ЖДҮ эрхлэгч гэдэг нь 199 хүртэл ажиллагчтай, жилд 1,5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой байгууллагыг хэлнэ.
- ЗБДС нь Улаанбаатар хотод 288, орон нутагт 153 батлан даалт гаргасан.
- Батлан даалтад орох зээлийн хувьд нэг тэрбум төгрөг хүртэлх, батлан даалтын хэмжээ 30-60%, зээлийн хугацаа 10 хүртэлх жил, батлан даалтын шимтгэл жил бүр 1%, жилийн хүү 12%-тай байна.
- Батлан даалтад орох шалгуур нь ЖДҮЭ байх, барьцаа хөрөнгийн дутагдалтай, хугацаа хэтэрсэн эсвэл чанаргүй зээлгүй, дор хаяж 1 жил үйл ажиллагаа явуулсан.
- ЖДҮЭ банкинд өргөдөл гаргаж улмаар банк ЗБДС-с судлах зөвшөөрөл авснаар банкны судалгааг хийж ЗБДС-д хүсэлт илгээнэ. ЗБДС дахин судалгаа хийснээр зээлийг баталж банк зээл олгоно.
- Одоогоор Төрийн банк, Худалдаа хөгжлийн банктай хамтарч ажиллаж байна.



Хэлэлцүүлгийн асуулт, хариултаас товч:

Асуулт: Хангайн бүсийн ЖДҮ-үүд юуг анхаарах вэ? Хангайн бүсийн хувьд ямар хөгжлийн бодлого явуулж байгаа вэ?

А.Мөнхболд: Хангайн бүс газарзүйн хувьд нилээн том, дэд бүтцийн хувьд сул холбогдсон. Энэ бүсэд хангай, тал хээр, говь хосолсон байдаг нь ХАА, уул уурхай, аялал жуулчлалын салбар хөгжих боломжийг олгож байна. Энэ бүсэд ЖДҮ хөгжүүлэх боломж бий гэхдээ Монголд нийтлэг тулгардаг бүх л асуудлууд бий. Өнөөдрийг хүртэл ЖДҮ-г хөгжүүлэх сан маш их мөнгө зарцуулсан. Харамсалтай нь өнөөдөр ЖДҮ төдийлөн хөгжиж чадаагүй. Бид нарын бодлого үнэхээр зөв байна уу? олгож байгаа зээлийн хэмжээ, хугацаа, нөхцөл нь ЖДҮ хөгжихөд хүрэлцэж байна уу? зах зээл байна уу? гэдэг асуудлууд байна. Иргэн, ААН тодорхой бизнес эрхлэх гэхээр хүү маш өндөр байна. Хангайн бүсийн хувьд ХАА-н салбарыг гол салбар гэж үзэж байгаа. ХАА-ын парк төслийг боловсруулж дууссан бөгөөд энэ тал дээр Япон улстай хамтрахаар санал тавьсан байгаа.

Асуулт: ЖДҮ-ийн талаар нилээдгүй бодлого бий. Засгийн газрын зүгээс ЖДҮ-г хөгжүүлэхэд ямар бодлого баримталж байна вэ?

Э.Бат-Идэр: Засгийн газраас хэрэгжүүлж буй бүх л бодлого улс орны болоод ард иргэдийн сайн сайхны төлөө хийгддэг. Бид Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн дагуу ажилладаг. Энэ хөтөлбөрийн хүрээнд ЖДҮ-н хувьд авах арга хэмжээний талаар 3,4 заалт байгаа. Тухайлбал, итгэлийн зээл олгож, ЖДҮ-д дэмжлэг үзүүлнэ. Үүнийг Сангийн яам, ХААХҮЯ-тай хамтарч хэрэгжүүлэхээр 42,5 тэрбум төгрөгийг төсөвлөөд байгаа. Мөн импортыг

орлуулах, экспортыг нэмэгдүүлэх 1 их наяд төгрөгийн төсөвтэй "Үйлдвэржилтийн 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Асуулт: Төрөөс явуулж буй бодлого орон нутагт хүрч чадаж байна уу? Яг хаана алдаа гарч байна вэ?

Ж.Сарангэрэл: Манай Хөвсгөлд гарч байгаа асуудлын хувьд гэвэл хамгийн эхний асуудал нь зээлийн асуудал юм. Зээл ямар замаар олгогдож байгаа мөн аймгийн бодлоготой нийцэж байгаа эсэх нь асуудал болоод байна. Зээлийг цогц байдлаар зөв замаар өгмөөр байна. Зээлийн хувьд үйлдвэр барихаар бол хугацааг нь уртасгах, тоног төхөөрөмж худалдаж авахаар бол шаардлагыг нь нарийсгах шаардлагатай байна. Тоног төхөөрөмжөө зээлээр аван үйл ажиллагаа явуулахад тэр нь мэргэжлийн хяналтаар тэнцэхгүй байх тохиолдол байна.

Асуулт: ЖДҮ-д банк бус санхүүгийн байгууллага болон даатгалын компаниудын хүртээмжийг нэмэгдүүлэхэд СЗХ ямар бодлого явуулж байна вэ?

Б.Наранжаргал: Одоогоор бол даатгалын 130, 533 ББСБ, 287 хадгаламж зээлийн хоршоод СЗХ-нд бүртгэлтэй байна. 66 ББСБ хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаагаас 22 нь Хангайн бүсэд үйл ажиллагаа явуулж байна. Хангайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын өөрийн хөрөнгийн өгөөж нь 2%-тай байдаг байна. Бичил даатгалыг хөгжүүлэх талаар ажлууд хийгдэж байгаа. Бичил даатгалын бүтээгдэхүүнийг манай даатгалын компаниуд зах зээлд нэвтрүүлнэ харин хууль эрх зүйн орчинг СЗХ бүрдүүлэх ёстой. Энэ талаар судалгаа, шинжилгээний ажлууд хийгдэж байгаа.

Асуулт: Орон нутгийн ЖДҮ эрхлэгчид зээлийн батлан даалтын сангаас хэрхэн зээл авах вэ?



Б.Ариунаа: Манайх Худалдаа хөгжлийн банк болон Төрийн банктай одоогоор гэрээ байгуулаад байгаа. Төрийн банк бол бүх аймгуудад салбартай байгаа. Төрийн банк дээр төслийн материалуудыг аваад эхэлчихсэн байгаа. Бараг Монгол Улсад байхгүй урт хугацаатай зээл байгаа. Энэ зээл нь 10 жилийн хугацаатай, эхний 2 жил нь үндсэн зээлээс чөлөөлөгдөнө. Жилийн 12-15 орчим хувийн хүүтэй. Бид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Азийн Хөгжлийн банкнаас зээл авч байгаа. Мөн манай сан нь валютын ханшны зөрүүний эрсдэлийг үүрч

байгаа. Арилжааны банк энэ зээлийн 40%-н эх үүсвэрийг бүрдүүлж байгаа. Тэгэхээр эндээс үүдээд жилийн 12-15 орчим хувийн хүүтэй байхаар тогтсон. Ер нь бол 60 орчим хувийн батлан даалттай зээл авбал хүү нь 12 орчим хувь байна. Батлан даалтын хэмжээ ихсэх тусам аа хүү багасдаг. Орон нутгийн бизнес эрхлэгч нарт энэ зээл нь нээлттэй байгаа. Зээлийн батлан даалтын сан 60%-н эрсдэлийг үүрч байгаа учир банкнаас ирсэн төслийг дахин судалж үзэж байгаа.

Өдрийн тойм: М.Сарандаваа, МҮХАҮТ-н орлогч дарга



Хэлсэн үгнээс:

"Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан нь тодорхой төрийн бодлого боловсруулах, аймгийн цаашдын бодлого тодорхойлоход нөлөөлөхүйц хэмжээний бичиг баримт болжээ гэдгийг хэлмээр байна. Бүх аймгийн бодлого боловсруулагч нар энэхүү тайланг харж байгаа юм байна, яаж сайжруулах вэ гэдгээ бодож байгаа юм байна, хойно байгаа аймгууд нь эмзэглэж байгаа юм байна. Бид бүсийн хэмжээнд хамтарч ажиллаж, ойлголцож чадна гэдэг найдвар энэ чуулганы өнгө аяс, оролцогчдын асуултууд, тэргүүлэгч оролцогчдын хэлж байгаа үгнээс төрж байна. Мөн манай оролцогч нар тогтвортой бодлогын талаар олон талаас нь ярилцлаа. 2 дахь хэлэлцүүлгээр бид аялал жуулчлалын салбарыг ярилцлаа.

Үүн дээр нэг зүйл хэлэхэд юугаараа ялгарах юм, яаж ялгарах юм бэ? гэдгийг маш сайн бодож тунгаах хэрэгтэй юм байна. Бидэнд маш олон баримт бичиг, бодлого байна. Гэхдээ бага ч гэсэн хэрэгжүүлж эхлээсэй гэж хүсэж байна. Оролцоо, ялгарал, хэрэгжүүлэлт хэрэгтэй байна. Цаг хугацаа явсаар байна. Чуулганы үр дүнд хүлээлт үүссэн байна аа, тийм учраас уриалга, зөвлөмж юм уу ойлголцолын бичиг баримт гаргах хэрэгтэй."



НЭЭЛТИЙН ҮГ

/2 ДАХЬ ӨДӨР/

Эдвард Андерсон

Азийн Сангийн Монгол дахь салбарын
суурин төлөөлөгчийг орлон гүйцэтгэгч



Хэлсэн үгнээс:

Азийн сангаас аймгуудын өрсөлдөх чадварын тайланг 4 дэхь жилдээ дэмжин ажиллаж байна. "Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан" бол аймаг бүр өөрсдийн өрсөлдөх чадварын давуу болон сул талыг харах мөн ялангуяа бүсчилсэн хөгжлийг сайжруулах боломжийг олгодог. Үг тайланг олон байгууллагууд дэмжиж, аймгуудыг илүү их өрсөлдөх чадвартай болгохын төлөө ажилладаг. Энэхүү өрсөлдөх чадварын индекс нь олон улсын аргачлалын дагуу тооцогддог. Шийдвэр гаргагчдын хувьд энэхүү тайлан нь чухал материал юм. Би Монголд ирээд сар болж байгаа хэдий ч Улаанбаатараас Хөвсгөл хүртэл явах замдаа танай баялаг болон байгалийн сайханыг харж явлаа. Хөрөнгө оруулалт маш хязгаарлагдмал гэж бодож байгаа хүмүүстэй би санал нийлэхгүй байна. Хөгжлийн маш их боломж та бүхэнд байна. Анхаарал тавьсанд баярлалаа."

Хэлэлцүүлэг 4: "Хангайн бүсийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөв"

Чиглүүлэгч: ЭЗБӨЧСТ-ийн Ерөнхий захирал Б.Лакшми



Тэргүүлэх оролцогчид:

1. ХХААХҮЯ-ны бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Х.Алтангэрэл
2. Өвөрхангай аймгийн ХХААГ-ын ҮХҮА-ны дарга Ц.Ариунаа
3. Өвөрхангай аймгийн ХАҮТ-ын дарга Б.Ууганбаяр



4. Хөвсгөл аймгийн ХХААГ-ын үйлдвэрлэл, газар тариалангийн албаны дарга Б.Нарантуяа
5. Монголын хөдөөг шинэчлэхийн төлөөх фермерүүдийн холбооны Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн Ж.Балдандорж
6. "Хөвсгөл Алтан дуулга" ХК-ийн захирал Д.Дуламсүрэн

ИЛТГЭЛ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөв

ХХААХҮЯ-ны бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Х.Алтангэрэл



Илтгэлээс онцлох:

- МУ-ын хүн амын 42,6% нь хөдөө амьдарч байна. 332 сумын 85 орчим хувь нь ХАА-н үйлдвэрлэлд суурилсан эдийн засагтай.
- 2015-2017 онд "Мах" үндэсний хөтөлбөр, 2017-2021 онд сав, баглаа боодол үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэж байна.
- ХАА-ын салбарт 619 мян.хүн ажиллаж нийт ажиллах хүчний 53,9 хувийг эзэлж байна.
- Нийт 311,4 мянган малчид байна. Өнгөрсөн онд малчдын тоо 13,5 хувиар өсжээ.
- Өнгөрсөн онд 343,7 мян.тн мах, 891,5 сая.л сүү, 38,584 тн ноос, ноолуур болон 14,001 мян.ш арьс, шир үйлдвэрлэжээ. Нийт мал сүргийн 45,3 хувийг ямаа, 41,6 хувийг хонь, 0,7 хувийг тэмээ, 5,9 хувийг адуу, 6,6 хувийг үхэр эзэлж байна.
- Газар тариалангийн салбарт 1414 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна.
- Өнгөрсөн онд 483,5 мян.тонн үр тариа, 165,3 мян.тонн төмс, 94,4 мян.тонн хүнсний ногоо хураажээ.
- Хүнсний салбарт 1914 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж, 13544 хүн ажиллаж байна.

Хэлэлцүүлгийн асуулт, хариултаас товч:

Асуулт: Өвөрхангай аймгийн ХАА-н салбарт гарч буй эерэг өөрчлөлтүүдээс туршлага хуваалцана уу. Мөн бусад хөрш зэргэлдээ аймгуудтай хамтран ХАА-н салбарыг хөгжүүлэх боломжын талаар ямар бодолтой байна вэ?

Ц.Ариунаа: Манай аймаг нь бүсчилсэн хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 зэрэг бодлогуудад түшиглэн эдийн засгийн бодлогын баримт бичгийг баталсан. Энэ баримт бичигт таван салбарыг тэргүүлэх салбараар

сонгосны дотор ХАА-н салбар нэг нь юм. ХАА-н салбар нь 100% нөөцөөс хамаарсан салбар бөгөөд нийт ажил эрхлэлтийн 60%, нийт цалингийн 40 гаруй хувийг хангаж байна. Бид ХАА-с гарч буй түүхий эдэд нэмүү өртөг шингээн эцсийн бүтээгдэхүүн болгох тал дээр илүү анхаарч ажиллаж байна. Арьс, ширний анхан шатны боловсруулалт хийх Австралийн төсөл хэрэгжиж байна.

Асуулт: ХАҮТ-аас ХАА-н салбарт үйл



ажиллагаа явуулж буй ААН-үүдэд ямар дэмжлэг үзүүлж байна вэ? ХАА-н салбарын бизнес эрхлэгчдэд ямар асуудал хамгийн гол бэрхшээл болж байна вэ?

Б.Ууганбаяр: МҮХАҮТ нь бизнес, төр хоёрын хооронд гүүр нь болж ажилладаг. ХАҮТ нь бизнес эрхлэгчдийг зээл, төсөлд хамруулах, бараа бүтээгдэхүүнийх нь сав баглаа боодол болон экспортод гаргах тал дээр нь дэмжлэг үзүүлдэг. Аймгийн ХАҮТ нь аймгийн удирдлагууд болон ХХААГ-тайгаа маш уялдаа холбоотой хамтран ажилладаг. ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудыг сургалт, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэргээр дэмжиж ажилладаг.

Асуулт: Хөвсгөл аймгийн хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр ямар арга хэмжээнүүд хэрэгжүүлж байна вэ? Цаашид хөдөө аж ахуйн салбарт бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг хэрхэн дэмжиж ажиллах вэ?

Б.Нарантуяа: Манай аймаг ХХАА-н салбарынхаа бодлогыг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний аюулгүй байдлын хөтөлбөрүүдтэй уялдуулж хэтийн зорилгыг боловсруулсан. Манай аймагт малын гоц халдварт өвчин байхгүй, эрүүл бүс нутагт хамаарагддаг. Цаашдаа энэ тал дээр илүү анхаарч өвчний голомт хаана байгааг шуурхай тогтоон, арилгаж байх тал дээр анхаарч ажиллана. Газар тариалангийн хувьд нийтдээ 29,000 га эргэлтийн талбай байна. Аймгийн төмсний хэрэгцээний 60 гаруй хувь, хүнсний ногооны 20 гаруй хувийг аймагтаа үйлдвэрлэж байна.

Асуулт: Өнгөрсөн хугацаанд явуулсан үйл ажиллагааныхаа туршлагаас хуваалцана уу. Төр засгийн зүгээс ямар дэмжлэг хэрэгтэй байна вэ?

Ж.Балдандорж: Манай холбоо нь

Монгол орон даяар 1200 гаруй гишүүнтэй. Хөвсгөл аймагт 35 гишүүн байна. Гадаад орнуудын сайн сортуудыг нутагшуулах тал дээр анхаарч ажиллаж байна. Үүний үр дүнд энэ жил лууван, байцаа сайн ургалаа. Аж ахуй нэгжүүд усалгааны системээ зөв хийж чадахгүй байгаагаас хэт хүйтрэх эсвэл хэт халах үеийн эрсдэлээс сэргийлж чадахгүй байна. Газар тариалан, мал аж ахуй хамт хөгжиж чадна. Малаас гарч буй ялгадас нь газар тариаланд бордоо болдог. Тэгэхээр фэрмийн чиглэлээр хөгжих хэрэгтэй байна. Би аймгийнхаа МСҮТ-д газар тариалангийн чиглэлийн анги нээгээчээ гэсэн санал тавиад анги нээлгэсэн. Гэвч тэнд сурах хүн алга аа. Энэ салбарт боловсон хүчний асуудал хүнд байна.

Асуулт: Бизнес эрхлэгчдэд тулгардаг гол бэрхшээл нь юу байна вэ? Төр засгийн зүгээс ямар дэмжлэг хэрэгтэй байна вэ?

Д.Дуламсүрэн: Газар дээр хэрэгждэг хууль ховор байна. Малчид, тариаланчид дайсан болцгоолоо. Хэн, хэнийг нь буруутгах арга алга. Тариаланчид талбайгаа хамгаалмаар байгаа бол малчид малаа бэлчээмээр байна. Тариалангийн бүс нутгийг тогтоож өгмөөр байна. Мөн хүний нөөцийн асуудал бол хамгийн том тулгамдсан асуудал болоод байна. Дөнгөж төгссөн боловсон хүчний хувьд ажил даах чадвар, хариуцлага, ухамсар муу байна.

Асуулт: Энэ бүс нутгийн хөдөө аж ахуйн салбарын боломж болон нөөцийг хэрхэн харж байна вэ? ХАА салбарын хүний нөөцийн асуудал дээр ямар арга хэмжээ авч байна вэ?

Х.Алтангэрэл: ХАА-н Их сургууль, яам хамтарч ажилладаг. Их сургууль төгссөн боловсон хүчин ажлын талбар дээр гараад их гологдож байна. Тэгэхээр сургалтын хөтөлбөрийг өөрчлөөд нийт



сургалтын 70%-ийг практик болгож өөрчлөхөөр ажиллаж байна. Мөн агрономич, мал зүйч, малын эмч нар их ховордож байна. Тэгэхээр тухайн

бүс нутагт нь МСҮТ-р дамжуулан хүмүүсийг сургах тал дээр анхаарч ажиллах чиглэлтэй байгаа.

Хэлэлцүүлэг 5: “Хангайн бүсийн хамтын ажиллагаа: Хурлын дүгнэлт цаашдын алхмууд”

Чиглүүлэгч: ЭЗБӨЧСТ-ийн Удирдах зөвлөлийн дарга П.Цагаан



Тэргүүлэх оролцогчид:

1. Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатар
2. Өвөрхангай аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж
3. Булган аймгийн БОАЖГ-ын дарга А.Гантөмөр
4. Орхон аймгийн БОАЖГ-ын дарга С.Жаргалсайхан
5. Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны дарга С.Баярмагнай

Хэлэлцүүлгийн асуулт, хариулт:

Асуулт: Та хурлын үр дүнг юу гэж үзэж байна? Цашид Хангайн бүсийн хамтын ажиллагааны талаар ямар боломжуудыг олж харав?

Л.Төмөрбаатар: Судалгаа, шинжилгээний асар том материалыг бидэнд өглөө. “Хөгжсөн Хөвсгөл 2030” хөтөлбөрийн хүрээнд Хөвсгөл аймгийн хувьд эдийн засгийг солонгоруулах, эдийн засгийн тамир тэнхээгээ сайжруулах шаардлагатай байна. Цашид энэхүү чуулганыг тодорхой хэмжээнд зохион байгуулдаг, гарсан санал санаачилгыг хэрэгжүүлдэг, иргэддээ хүрэх ажлуудыг хийх ёстой талаар бүх аймгууд санал

нэгтэй байгаа. Бусад Хангайн бүсийн аймгуудтайгаа хамтарч ажиллая.

Асуулт: Та хурлын үр дүнг юу гэж үзэж байна? Цашид Хангайн бүсийн хамтын ажиллагааны талаар ямар боломжуудыг олж харав?

А.Ишдорж: Зам бол мөнгө. Тайлангаас харахад дэд бүтцийн асуудал ялангуяа замын асуудал тулгамдсан асуудал байна. Босоо тэнхлэгийн 325 км замыг холбовол Монгол Улсад босоо тэнхлэгийн хос зам бий болох боломж байна. Энэ зам баригдвал аялал жуулчлал, үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж байна. Өрхийн хэмжээнд бус



үйлдвэрлэлийн хэмжээнд хөгжүүлэх боломжтой.

Асуулт: Та хурлын үр дүнг юу гэж үзэж байна? Цаашид Хангайн бүсийн хамтын ажиллагааны талаар ямар боломжуудыг олж харав?

А.Гантөмөр: Аймаг өөрийнхөө ямар түвшинд явж байгааг харах, өндөр өрсөлдөх чадвартай аймгуудаас суралцах, хөгжлийнхөө чиг баримжааг тодорхойлох боломж байна. Босоо тэнхлэгийн замыг барьвал манай 6 аймаг холбогдож цаашид илүү хурдацтай хөгжих боломж байна. Манай аймаг газар тариалангаараа бусад аймгуудаасаа арай илүү хөгжсөн учир бусад аймгуудаа хадлан, тэжээлээр хангах боломжтой. Мөн усаа ашиглах хэрэгтэй байна. 5 том гол байна. Усаа хуримтлуулж говийн бүсийг усаар хангах боломж байна. Усан аялал жуулчлалын маршрутыг хөгжүүлэх боломж байна.

Асуулт: Та хурлын үр дүнг юу гэж үзэж байна? Цаашид Хангайн бүсийн хамтын ажиллагааны талаар ямар боломжуудыг олж харав?

С.Жаргалсайхан: Орхон аймгийн хувьд босоо тэнхлэгийн замыг юун түрүүнд байгуулах ёстой хэмээн үзэж байгаа. Мөн аймгууд тогтвортой хөгжлийн бодлогоороо хоорондоо уялдан, хамтран ажиллах ёстой. Орхон аймгийн хувьд зэргэлдээх аймаг, сумдуудтайгаа хамтын ажиллагааны гэрээг байгуулж, энэ чиглэлээр иргэд болон бизнесийнхэнтэй нягт хамтын ажиллагаатай явж байгаа. Хүний хөгжлийн асуудал дээр илүү анхаарч

ажиллаж байгаа. Энэ тал дээр нийтдээ 2 тэрбум төгрөг зарцуулаад байна. Ахмадууд, багш, эмч, хашаандаа хаустай иргэн зэрэг хөтөлбөрүүдийн хүрээнд нилээн шинэлэг ажлуудыг хийж байна. Аялал жуулчлалын салбарын хувьд манай аймаг онцлог талтай. Учир юу вэ гэвэл манай аймаг аялал жуулчлалын тулгуур төв болох Хөвсгөл аймаг явах зам дагуу байдаг. Хөх Монгол Цогцолбор болон Сэлэнгэ амралтын бааз зэрэг газруудаа Монгол аялал жуулчлалын маршрутад оруулах ажлыг хийж байна.

Асуулт: Та хурлын үр дүнг юу гэж үзэж байна? Цаашид Хангайн бүсийн хамтын ажиллагааны талаар ямар боломжуудыг олж харав?

С.Баярмагнай: Чуулган маш амжилттай боллоо. Хангайн бүсэд өрсөлдөх чадвараараа тэргүүлдэг аймаг байдаг мөн доогуур ордог аймгууд ч байдаг. Тэгэхээр бид нэг нэгнээсээ туршлага суралцаж болохоор байна. Үзэсгэлэн худалдаан дээрээс харж байхад бид бүс дотроо худалдаа хийгээд байх бүрэн боломжтой. Гэвч дэд бүтцийн асуудал хүнд байна. Хангайн бүсийн хувьд аялал жуулчлалын бүхий л орчин нөхцөл бүрдсэн гол бүс юм. Тийм ч учраас бид хангайн бүсийн аялал жуулчлалын нэгдсэн маршрутыг бий болгох боломж байна. Энэ дашрамд хэлэхэд аймгуудын аялал жуулчлалын газруудын уулзалтыг Баянхонгор аймагт зохион байгуулах санал тавьж байна. Энэхүү уулзалтаар Хангайн бүсийн аялал жуулчлалын маршрутыг хамтраад хийх юм.



ХААЛТЫН ҮГ

Л.Төмөрбаатар

Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга

“Хангайн бүсийн өрсөлдөх чадварын чуулган Хөвсгөл аймгийн Мөрөн хотод 2 өдөр амжилттай үргэлжилж ийнхүү дуусаж байна. Чуулганы хүрээнд олон төрлийн санал, санаачилга гарлаа. Энэ чуулганд оролцож буй аймгууд тодорхой саналуудыг гаргасан. Аялал жуулчлал, бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллах, аймгууд сул талаа нөхөх зэргээр 2018 оноос бодит ажил болгон иргэддээ хүртээмжтэй байхаар хамтарч ажиллана гэж бодож байна. Энэ чуулганыг зохион байгуулсан, бидэнд маш их мэдээлэл өгсөн, оюуны томоохон хөрөнгө оруулалт хийсэн бүх хүмүүст Хөвсгөл аймгийн төр захиргааны байгууллагын нэрийн өмнөөс баяр хүргэж цаашдын ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө. Ингээд Хангайн бүсийн өрсөлдөх чадварын чуулганд оролцсон хүмүүсдээ мөн баяр хүргэж, амжилт хүсье.

П.Цагаан

ЭЗБӨЧСТ-ийн Удирдах зөвлөлийн дарга

За тэгэхээр “Хангайн бүсийн өрсөлдөх чадварын чуулган 2017”-г Хөвсгөл аймгийн Мөрөн хотод 2 өдөр амжилттай зохион байгууллаа. Юуны өмнө жил бүр энэхүү арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлдэг “Конрад-Аденауэр-Сан”-д талархал илэрхийлье. Энэхүү чуулганыг хүлээн авч, шаардлагатай зүйлээр хангасан Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатар болон чуулганд өргөн бүрэлдэхүүнтэйгээр хүрэлцэн ирж оролцсон Орхон аймгийн ИТХ-ын дарга П.Пүрэвхагва, Өвөрхангай аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж, Булган аймгийн ИТХ-ын дарга М.Оюунбат, Архангай, Баянхонгор аймгийн зочид төлөөлөгчид болон мөн Улаанбаатар хотоос хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчид түүний дотор ЗГХЭГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Э.Бат-Идэр, “Конрад-Аденауэр-Сан”-ийн төслийн менежер Б.Сүхбат, Азийн Сангийн Монгол дахь салбарын суурин төлөөлөгчийг орлон гүйцэтгэгч Эдвард Андерсон болон ҮХГ-ын судалгаа шинжилгээний албаны дарга А.Мөнхболд, СЗХ-ны судалгаа эрсдэлийн шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Наранжаргал, Зээлийн батлан даалтын сангийн, Захиргаа төлөвлөлтийн газрын дарга Б.Ариунаа, БОАЖЯ-ны аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Ц.Гэрэлсайхан, Монголын аялал жуулчлалын холбооны гадаад



харилцаа, маркетингийн менежер Б.Булган, нарт талархал илэрхийлье. Хөвсгөл аймгийн ЗДТГ, Хөгжимт драмын театрын хамт олонд бас талархал илэрхийлье. Чуулганы үйл явцыг түмэн олонд хүргэсэн нийт хэвлэл мэдээллийнхэнд талархал илэрхийлье. Хангайн бүсийн чуулганыг дэмжсэн, хамтарч ажилласан, идэвхитэй оролцсон бүх байгууллага, хувь хүмүүст гүн талархал илэрхийлье. Зарим нэг хүмүүсийн нэрсийг дурьдаагүй орхисон бол хүлцэл өчье. Энэхүү Хангайн бүсийн өрсөлдөх чадварын чуулганаар аймгуудын өрсөлдөх чадварын тайланд хөндөгдсөн асуудлууд, ялангуяа аялал жуулчлал, ЖДҮ, санхүүжилтийн шинэ боломж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, мониторинг, ХАА, бүсийн хөгжил хамтын ажллагаа гээд олон сэдвийг хөндөж ярилцлаа. Чуулган үр дүнтэй ажил хэрэгч болж оролцсон хүн бүрт нэгийг бодогдуулсан байх. Бид нэг эх оронтой. Бид хамтдаа үзэсгэлэнт эх орон газар нутгаа хамгаалж үлдэх, зөв ашиглах, ард иргэдээ сайн сайхан амьдрүүлж, ажлын байр бий болгоход төрийн байгууллага, хувийн хэвшил хамтарч ажиллах хэрэгтэй юм байна, бүс нутгийнхаа хэмжээнд хамтарч ажиллах хэрэгтэй юм байна. Аймаг болгон адилхан юм хийх биш, нэг нэгийгээ нөхсөн, дэмжсэн бодлого боловсруулж нэмүү өртгийн сүлжээ бий болгох шаардлагатай юм байна. Маш олон боломжууд байна, гагцхүү тэрийгээ л ажил хэрэг болгох хэрэгтэй байна. Үүний тулд эрүүл саруул өрсөлдөж, бас ухаалаг хамтын ажиллагаа чухал юм байна гэсэн уур амьсгал танхимд болон бусад газар төрлөө гэж бодож байна. Айл гэрийн жаргал зовлон адилгүй байдаг шиг аймаг бүрийн амьдрал, хөгжлийн сорилт ондоо ондоо байгаа. Гэвч бид бүхэнд нэг зүйл яг адил тэнцүү байгаа. Тэр бол цаг хугацаа. Хоногт 24 цаг, жилд 365 хоног байгаа. Түүнийг хэрхэн зөв ашиглаж ажиллаж чадсан аймаг, компани, айл өрх хувь хүний амьдрал, ажлын бүтээл, ирээдүй илүү өөдрөг, илүү гэгээлэг, илүү өрсөлдөх чадвартай байна. Үүнд би итгэдэг.

Өрсөлдөх чадвартай Монголын төлөө үйл хэрэгт хувь нэмрээ оруулцгаая!



ЗУРГИЙН ЦОМОГ

Чуулганы үеэр Хангайн бүсийн бизнес эрхлэгчид цуглан Мөрөн хот дахь Чингүнжавын талбайд “Намрын ногоон өдөр” үзэсгэлэн худалдаанд оролцов. Энэхүү үзэсгэлэн худалдаанд Хөвсгөл аймгийн сумдуудын бизнес эрхлэгчид болон хангайн бүсийн Булган аймгаас “Буман Сүхэс” ХХК, “Баясгалант бүрд” хоршоо, “Им бүтэн бүтээл” хоршоо, Өвөрхангай аймгаас “Өв сүү” хоршоо, хувиараа бизнес эрхлэгч Д.Болорчулуун, “Ноос Ирээдүй” ХХК, Орхон аймгаас “Анд-Энерги” ХХК, Архангай аймгаас “Ар арвижин дэлгэрэх хоршоо”, “Их Улиастай” нөхөрлөл, хувиараа бизнес эрхлэгч Ч.Өнөржаргал нар оролцлоо.







2017 оны 10-р сарын 13 буюу чуулганы сүүлийн өдөр чуулганд оролцогчид Хөвсгөл далайтай танилцах аялал хийж, Хөвсгөл далайн эрэг дагуу байрладаг “Дөл” тур баазад байрлав. Тус бааз нь 2002 онд байгуулагдсан бөгөөд нэг ээлжиндээ 120 хүн хүлээн авах багтаамжтай бөгөөд Хатгал тосгоноос 5 км зайтай юм.





ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Ерөнхий сайд Амарын гудамж 29,
Сан бизнес центр 9-р давхар

Утас: 976-11-321927
976-11-321926

Цахим шуудан: info@ecrc.mn

Цахим хаяг: www.ecrc.mn

www.aimagindex.mn

Фэйсбүүк хуудас: www.facebook.com/ecrcmn

Твиттер хуудас: www.twitter.com/ursulduhchadvar